


## ХАРИЛЦАГЧИД ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ ГЭРЭЭ

Энэхүү “Харилцагчид үйлчилгээ үзүүлэх гэрээ”-г нэг талаас Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүргийн 1-р хороо, 14210, Энхтайваны өргөн чөлөө 19 /  бахдал эрдэнэс мэдэрэгч / хаягт орших Худалдаа, хөгжлийн банк (цаашид “Банк” гэх)-ны (регистрийн дугаар.....) (цаашид “Харилцагч” хамтад нь “Талууд” гэх), нар дараах нөхцөлүүдийн талаар харилцан тохиролцож байгуулаа.

### НЭГ, НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Энэ гэрээгээр Банк харилцагчийн хүсэлтийн дагуу харилцагчийг банкны бүтээгдэхүүн, үйлчилгээнд бүртгэх, төлбөр тооцооны үйлчилгээ үзүүлэх, Харилцагч төлбөр тооцооны үйлчилгээг авах, бүтээгдэхүүн, үйлчилгээний шимтгэл Банканд төлөх, данс нээх, хаах, зээл авах болон зайнаас банкны үйлчилгээ үзүүлэхтэй холбоотойгоор талуудын эрх, үүрэгтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулаа.

### ХОЁР, БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ ҮНДСЭН НӨХЦӨЛ

2.1. Харилцагч Банктай дараах банкны мэдээлэл, үйлчилгээ авах сувгуудаар дамжуулан харилцана. Үүнд:

- 2.1.1. Банкны салбар, тооцооны төвүүд;
  - 2.1.2. Банкны лавлах төвийн утасны дугаар (19001977, 70161988);
  - 2.1.3. Банкны лавлах төвийн цахим шуудангийн хаяг (info@tdbm.mn);
  - 2.1.4. Банкны www.tdbm.mn цахим хуудас;
  - 2.1.5. Банкны чат программ болон олон нийтийн сүлжээний чат;
  - 2.1.6. Харилцагчтай зайнаас холбогдох боломж бүхий банкны бусад хэрэгслүүд.
- 2.2. Харилцагчийн хүсэлтийн дагуу түүний Банканд өгсөн үнэн, зөв мэдээллийг үндэслэн Банк харилцагчид дараах бүтээгдэхүүн, үйлчилгээг үзүүлнэ. Үүнд:
- 2.2.1. Харилцах данс (цаашид “Данс” гэх) нээж, төлбөр тооцооны үйлчилгээ үзүүлэх;
  - 2.2.2. Төлбөрийн дебит карт (цаашид “Карт” гэх) олгож, төлбөр тооцооны үйлчилгээ үзүүлэх;
  - 2.2.3. Ти Ди Би Онлайн үйлчилгээ (цаашид “Ти Ди Би Онлайн” гэх)-нд бүртгэж, зайнаас банкны үйлчилгээг үзүүлэх;
  - 2.2.4. Мост Мони үйлчилгээ (цаашид “Мост Мони” гэх)-нд бүртгэж, зайнаас банкны үйлчилгээг үзүүлэх;
  - 2.2.5. Хуримтлалын үйлчилгээ (цаашид “Хуримтлал” гэх)-нд бүртгэж, харилцагчийн заасан хугацаа, төгтмөл дүнгээр болон мянгалчлал, хувийн дагуу төлбөр тооцоог гүйцэтгэх, бүртгэлтийг сунгах, цуцлах;
  - 2.2.6. Автомат билл төлбөрийн үйлчилгээ (цаашид “Автомат билл төлбөр” гэх)-нд бүртгэж, нэхэмжлэгч байгууллагаас ирүүлсэн нэхэмжлэхэд үндэслэн харилцагчийн данснаас төлбөрийг шилжүүлэх;
  - 2.2.7. Мэдэгдлийн үйлчилгээ (цаашид “Мэдэгдлийн үйлчилгээ” гэх)-нд харилцагчийн банканд бүртгэлтэй холбоо барих мэдээлэл болох цахим шуудангийн хаяг болон гар утасны дугаараар бүртгэж, харилцагчийн банканд дахь дансны гүйлгээ, үлдэгдлийн мэдээлэл болон бусад төрлийн лавлагааны талаар мэдэгдэл илгээх;
  - 2.2.8. Лавлах төвийн зайн сувгуудаар үйлчлүүлж мэдээлэл, лавлагаа авах, зайнаас зөвшөөрөгдсөн бүтээгдэхүүн, үйлчилгээнд бүртгүүлэх;
  - 2.2.9. Банкнаас зайнаас олгохоор санал болгож буй зээлийн үйлчилгээг авахаар гаргасан харилцагчийн хүсэлтийг хүлээн авах, хүсэлтийг судалж, холбогдох шаардлага хангасан тохиолдолд харилцагчийн хүсэлтийн дагуу зээл олгох.

2.3. Банк харилцагчид бүтээгдэхүүн, үйлчилгээг үзүүлэхдээ дараах хэлбэрээр харилцагчийг баталгаажуулаа. Үүнд:

- 2.3.1. Банкны салбар, тооцооны төвөөр үйлчилгээ үзүүлэх бол харилцагчийг баталгаажуулах үндсэн мэдээлэл нь харилцагчийн зураг, баталгаат гарын үсэг, иргэний хүчин төгөлдөр баримт бичиг байна.
- 2.3.2. Банкны бүтээгдэхүүн, үйлчилгээг зайнаас авах тохиолдолд энэхүү гэрээний 2.2-д заасан бүтээгдэхүүн, үйлчилгээнд ашиглагдах нэвтрэх нэр, нууц үг, пин код мөн Банканд бүртгэлтэй харилцагчийн цахим шуудангийн хаяг, утасны дугаар, нууц асуулт, хариулт болон бусад баталгаажуулалтын хэрэгслүүд нь тухайн харилцагчийн баталгаат гарын үсэг (тамга, тэмдгийн дардас)-ын адил хүчин төгөлдөр болохыг Талууд үүгээр зөвшөөрч, харилцан тохиролцов.

2.4. Харилцагч зээл авах болон данс нээлгэх хүсэлтийг зайнаас илгээсэн тохиолдолд энэхүү гэрээний 2.3.2-д заасан баталгаажуулах хэлбэрээр тухайн бүтээгдэхүүн, үйлчилгээний гэрээг цахимаар баталгаажуулж болох ба ийнхүү баталгаажуулсан нь уг гэрээг бичгээр байгуулсантай нэгэн адил хүчин төгөлдөр байхаар Талууд харилцан тохиролцов.

2.5. Нийтгэл зарласан банкны бүтээгдэхүүн, үйлчилгээний ерөнхий нөхцөл (цаашид “БҮЕН” гэх)-д тухайн бүтээгдэхүүн, үйлчилгээний ерөнхий нөхцөл, талуудын эрх, үүрэг, хариуцлагыг, Хүү, шимтгэлийн ерөнхий нөхцөл (цаашид “ХШЕН” гэх)-д банкны бүтээгдэхүүн үйлчилгээний хүү, шимтгэлийг тус тус хамруулан ойлгоно.

2.6. Харилцагч энэхүү гэрээнд гарын үсэг зурж баталгаажуулснаар энэхүү гэрээ хүчин төгөлдөр болох ба тухайн үед мөрдөгдөж байгаа БҮЕН, ХШЕН-тэй танилцаж, бүрэн хүлээн зөвшөөрсөн болно. Цаашид БҮЕН, ХШЕН-д орох нэмэлт, өөрчлөлтүүдийг Харилцагч Банкны www.tdbm.mn цахим хуудсаар орж танилцах, Банк харилцагчийн Банканд бүртгүүлсэн цахим шуудангийн хаягаар дамжуулан мэдээлэхээр тохиролцов.

2.7. Банк цахим хуудсаараа дамжуулан БҮЕН, ХШЕН-д нэмэлт, өөрчлөлт орох талаар нийтгэл мэдээлснээр харилцагчаас тухайн нэмэлт, өөрчлөлтийн талаар энэхүү гэрээнд заасан хугацаанд санал, хүсэлт ирүүлэхгүй бол БҮЕН, ХШЕН-д орсон нэмэлт, өөрчлөлтийг Талууд хүлээн зөвшөөрсөн гэж үзэхээр харилцан тохиролцов.

2.8. Харилцагч нь энэхүү гэрээг Банктай байгуулснаар Банканд Зээлийн мэдээллийн сан болон Цахим мэдээллийн сангаас өөрийн мэдээллийг харах эрхийг зөвшөөрсөн болно.

2.9. Энэхүү гэрээний дагуу ямар төрлийн бүтээгдэхүүн, үйлчилгээ авч байгаа болох нь Харилцагчийн уг гэрээг байгуулах үед гаргасан болон цаашид гаргах хүсэлтээр тодорхойлогдоно. Энэхүү хүсэлт нь Гэрээний хавсралт болно.

2.10. Банкны программын эсхүл үйл ажиллагааны алдаа /хүлээн авагчийн нэр, данс зөрүүтэй шилжсэн/-аас үүдэн харилцагчийн дансанд илүү мөнгө орсон тохиолдолд харилцагчийн данснаас уг мөнгөн хөрөнгийг үл маргах журмаар суутган авах зөвшөөрлийг харилцагч нь банканд үүгээр олгож байгаа болно.

### ГУРАВ. ТАЛУУДЫН НИЙТЛЭГ ЭРХ, ҮҮРЭГ

#### 3.1. Банк дараах үүрэг хүлээнэ. Үүнд:

3.1.1. Харилцагчийн гүйцэтгэсэн төлбөр тооцоог дансны боломжит үлдэгдэлд багтаан хүлээн авсан дарааллын дагуу гүйцэтгэх;

3.1.2. Харилцагчийн дансны дугаар, гүйлгээний талаарх мэдээлэл, дансны үлдэгдэл болон түүнтэй холбоотой бусад мэдээллийн нууцлалыг хадгалж, хуульд зааснаас бусад тохиолдолд бусад гаргаж өгөхгүй байх;

3.1.3. Харилцагчийн дансны үлдэгдэлд ХШЕН-д заасны дагуу хүү төлөх;

3.1.4. Шүүх, прокурор, цагдаа, татварын байгууллага болон бусад үл маргах журмаар төлөх төлбөрөөс бусад тохиолдолд харилцагчийн зөвшөөрөлгүйгээр данснаас зарлагын гүйлгээ хийхгүй байх;

3.1.5. Харилцагчид дансны хуудла, гүйлгээ, үлдэгдлийн талаарх мэдээллийг харилцагчийн хүсэлтийг үндэслэж, Банкны тодоод заавар, журмын дагуу гаргаж өгөх;

3.1.6. Банкны буруугаас хийгдсэн алдаатай гүйлгээг даруй заруулж, харилцагчийг хохиролгүй болгох;

3.1.7. БҮЕН, ХШЕН-д орох нэмэлт, өөрчлөлтүүдийг Банкны www.tdbm.mn цахим хуудас болон харилцагчийн Банканд бүртгүүлсэн цахим шуудангийн хаягаар дамжуулан тухай бүр мэдээлэх;

3.1.8. Харилцагчийн харьяаллын улс нь Монгол Улсын Засгийн газартай давхар татварын гэрээ байгуулсан бол харилцагчийн харьяаллын улсаас олгосон татвар төлөгчийн сертификат (тухайн татварын жилд хамаарах), гадаад паспортыг үндэслэн хүүгийн орлогод ногдох татварыг давхар татварын гэрээнд заасан хэмжээгээр суутгаж татварын байгууллагад шилжүүлэх;

3.1.9. Харилцагч тухайн татварын жилд хамаарч татвар төлөгчийн сертификат, гадаад паспортыг банк хүүгийн орлого олгохоос аялын 3 өдрийн өмнө Банканд өгөөгүй бол хүүгийн орлогод ногдох татварыг Монгол улсын хууль тогтоомжид заасны дагуу суутгаж, татварын байгууллагад шилжүүлэх;

3.1.10. Хууль, гэрээгээр хүлэсэн бусад үүргийг биелүүлэх.

#### 3.2. Банк дараах эрх эдэлнэ. Үүнд:

3.2.1. БҮЕН болон ХШЕН-д өөрийн санаачилгаар нэмэлт, өөрчлөлт оруулах;

3.2.2. Харилцагчийн данснаас зээл, хүүгийн төлбөр болон бүтээгдэхүүн, үйлчилгээний шимтгэлийг БҮЕН болон ХШЕН-д заасны дагуу үл маргах журмаар суутган авах;

3.2.3. Харилцагчийн шимтгэл төлөх дансны үлдэгдэл хүрэлцэхгүй байгаа тохиолдолд түүний бусад данснаас суутган авах;

3.2.4. Харилцагчийн бүх төрлийн дансны үлдэгдэл шимтгэл төлөхөд хүрэлцэхгүй буюу боломжгүй байгаа тохиолдолд Харилцагчид үйлчилгээ үзүүлэхээс татгалзах;

3.2.5. Харилцагчийн хийсэн төлбөр тооцооны үнэн зөв эсэхэд эргэлзсэн, хүлээн зөвшөөрөхгүй байгаа, эсхүл алдаатай, илүү, дутуу болон давхар хийсэн аливаа маргаантай гүйлгээг (цаашид “Маргаантай гүйлгээ” гэх)-г шийдвэрлэхийн тулд маргаантай гүйлгээний дүнгээр дансанд түр хаалт тавих;

3.2.6. Маргаантай гүйлгээнд харилцагчийн буруутай үйлдэл нотлогдвол түүний данснаас хохирол, зардлыг үл маргах журмаар суутган авах;

3.2.7. Харилцагч Гэрээгээр хүлэсэн үүрэг болон бүтээгдэхүүн, үйлчилгээг хэрэглэх заавар, зөвлөмжийг зөрчсөн тохиолдолд Банк дараах үйлдлийг хийх эрхтэй. Үүнд:

3.2.7.а. Харилцагчийн гүйлгээ хийх эрхийг гүдгэлзүүлж, гэрээгээр хүлэсэн үүрэг биелүүлж, зөрчлийг арилгах арга хэмжээ авахыг шаардах;

3.2.7.б. Харилцагчийн хийх гүйлгээ болон гүйлгээний дүнд тодорхой хязгаарлалтуудыг тогтоох;

3.2.7.в. Харилцагч нь Гэрээгээр хүлэсэн үүрэг биелүүлэхгүй бол Гэрээг нэг талын санаачилгаар цуцалж, бүтээгдэхүүн, үйлчилгээний эрхийг цуцлах;

3.2.7.г. Харилцагчийн буруугаас Банк болон аливаа этгээдэд хохирол учирсан бол Харилцагчийн Банкны дахь данснаас хохирлыг үл маргах журмаар суутган авах, дансны үлдэгдэл нь хохирлыг бүрэн барагдуулж хүрэхгүй тохиолдолд хууль заасны дагуу бусад арга хэмжээг авах;

3.2.7.д. Дансны үлдэгдэл санаатай болон санамсаргүй улайлган (өр болгох буюу дансны боломжит үлдэгдлээс хэтрүүлэх) ашигласан тохиолдолд төлж барагдуулахыг шаардах, бусад данснаас суутган авах, улайлтыг төлүүлэх талаар хуульд заасны дагуу бусад арга хэмжээг авах.

3.2.8. Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу харилцагчийн дансанд БҮЕН болон ХШЕН-ийн дагуу олгогдох хүүгийн орлого, түүнтэй адилтгах бусад орлогод ногдуулах албан татварыг суутгаж, холбогдох татварын байгууллагад шилжүүлэх;

3.2.9. Хууль болон гэрээгээр хүлэсэн үүрэг биелүүлэхийг харилцагчаас шаардах;

3.2.10. Банкны буруугаас алдаатай гүйлгээ хийгдсэн тохиолдолд харилцагчийн харицах болон хугацаагүй хадгаламжийн данснаас үл маргах журмаар суутган авч, алдаатай гүйлгээг заруулах. Ийнхүү Банк алдаатай гүйлгээг заруулсныг Харилцагчийн бичгээр өгсөн зөвшөөрлийн үндсэн дээр гүйцэтгэсэн гүйлгээ гэж үзнэ;

3.2.11. Хууль болон гэрээнд заасан бусад эрх.

#### 3.3. Харилцагч дараах үүрэг хүлээнэ. Үүнд:

3.3.1. Банкны цахим хуудсанд нэвтэрч БҮЕН болон ХШЕН-д оруулсан нэмэлт, өөрчлөлттэй танилцах;

3.3.2. Карт, пин код, гар утас, нэвтрэх болон гүйлгээний нууц үг, бусад баталгаажуулалтын хэлбэрийг бусад дамжуулсан, заруулсан, алдсан, нууцлалын төхөөрөмжийг гээсэн, алдсан, нэвтрэх эрхийг зөвшөөрөлгүйгээр ашиглан аливаа эх үүсвэрээ гүйлгээ хийх оролдлого гаргасныг мэдсэн тохиолдолд Банканд нэн даруй мэдэгдэж үйлчилгээний эрхээ түр хаалгах, мэдэгдэхгүйн улмаас үүсэх хохирлыг бүрэн хариуцах;

3.3.3. Дансанд заавал байлгах үлдэгдлийг тогтмол байршуулах;

3.3.4. Дансны үлдэгдлийг улайлган ашигласан тохиолдолд БҮЕН болон ХШЕН-д заасны дагуу шимтгэл, хүү, торгууль болон улайлгасан үндсэн дүнг яаралтай төлж барагдуулах;

3.3.5. Харилцагч банкны үйлчилгээг авахдаа ургийн овог, эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, төрсөн он, сар, өдөр, регистрийн дугаар, иргэншил, оршин суугаа хаяг, эрхэлж буй ажил мөргөжил, үйл ажиллагааны чиглэл, утасны дугаар, цахим хаяг болон бусад мэдээллийг банканд өгөх ба мэдээлэл өөрчлөгдсөн бол тухай бүр нь мэдээллийн шинэчлэлтийг хийлгэх;

3.3.6. Банк Гэрээний 3.3.5 дахь заалтад заасан мэдээллийн шинэчлэлт хийлгэх болон тодруулаа авах тухай мэдэгдэл хүргүүлсэн тохиолдолд холбогдох мэдээллийн банканд тухай бүр өгөх;

3.3.7. Дансыг хамтран эзэмшигч, хамтран эзэмшэх эрх бүхий нэмэлт карт эзэмшигч болон нэмэлт утасны дугаарын бүртгэлээр дамжуулан Банкны бүтээгдэхүүн, үйлчилгээг ашиглаж гүйлгээ хийхтэй холбоотой бий болох бүх төрлийн гүйлгээ, төлбөр тооцоо, төлбөл зохих үйлчилгээний хүү, шимтгэл, түүний үнэн бодит байдал, маргаан, эрсдэлийг бүрэн хариуцах;

3.3.8. Харилцагч дараах үйлдлүүдэд гарсан хохирлыг бүрэн хариуцна. Үүнд:

3.3.8.а. Харилцагч гэрээний 3.3.5, 3.3.6 дахь заалтад заасан мэдээлэлд өөрчлөлт орох тухай бүрт, мөн банкнаас мэдээллийн шинэчлэлт хийлгэх болон тодруулаа авах тухай мэдэгдэл хүргүүлсэн тохиолдолд өөрийн мэдээллийг банканд мэдэгдэх, өөрчлүүлэх, шинэчлүүлэх ба Харилцагч энэ үүрэг биелүүлэхгүйгээс банк болон банкны харилцагч бусад этгээдэд учирсан хохирол;

**ЗУРГАА. ХАРИУЦЛАГА**

- 3.3.8.б. Бүтээгдэхүүн, үйлчилгээний заавар, гарын авлагыг дагаж мөрдөх үүрэгтэй бөгөөд энэхүү үүрэг зөрчсөнөөс үүсэх аливаа хохирол;
  - 3.3.8.в. Дансны гүйлгээний хуулга тогтмол шалгаж ямар нэгэн маргаантай буюу хүлээн зөвшөөрөхгүй гүйлгээ хийгдсэн тохиолдолд гүйлгээ хийгдсэнээс хойш хуанлийн 30 хоногийн дотор Банканд мэдэгдэж шалгуулах, мэдэгдэгүйн улмаас бусад Банканд хандаж маргаан үүсгэх хугацаа өнгөрснөөс үүсэх хохирол;
  - 3.3.8.г. Дэс эсвэл карт эзэмшигч, картаар үйлчлэгч байгууллага болон карт гаргагч, эсвэл картаар үйлчлэгч банкны аль нэг талаас үл зөвшөөрөн маргаан үүсгэсэн карт болон дансны гүйлгээ шалгах явцад харилцагч нь Гэрээгээр хүлээсэн үүрэг болон бүтээгдэхүүн, үйлчилгээг хэрэглэх заавар, зөвлөмжийг зөрчсөн болох нь нотлогдсон тохиолдолд гарсан хохирол, зардал;
  - 3.3.8.д. Пин код, нууц үг болон бусад баталгаажуулалтын мэдээллийг мартсан, буруу оруулсаны улмаас гүйлгээ хийж чадаагүй, гүйлгээ саатсанаас үүсэх аливаа хохирол;
  - 3.3.8.е. Бүтээгдэхүүн, үйлчилгээг ашиглах явцад харилцагч нь гэрээнд заасан үүргийг биелүүлээгүйгээс Банканд болон гуравдагч этгээдэд санаатай болоод санамсаргүйгээр үүсгэсэн /үүсэх аливаа хохирол, зардал, асуудал;
  - 3.3.9. Харилцагч нь Монгол улс болон тухайн улсын Засгийн газар хооронд давхар татварын гэрээ байгуулсан гадаад улсын иргэн бол банк хүүгийн орлого олгохоос ажлын 3 хоногийн өмнө татвар төлөгчийн сертификат (тухайн татварын жилд хамаарах), гадаад паспортыг Банканд өгснөөр давхар татварын гэрээнд заасан хэмжээгээр татвар суутгуулах үүрэг үүснэ.
  - 3.3.10. Хэрэв гэрээний 3.3.9-д зааснаар хүүгийн орлого авахаас өмнө татварын төлөгчийн сертификат, гадаад паспортыг Банканд өгөөгүй бол хүүгийн орлогыг Монгол Улсын хууль тогтоомжид заасны дагуу суутгуулах үүрэгтэй.
  - 3.3.11. Харилцагч нь Ти Ди Би Онлайн үйлчилгээг ашиглан өөрийн сонгосон багцаас хамааран Банкны үйлчилгээ авах боломжтой ба тухайн сонгосон Ти Ди Би Онлайн багцын үйлчилгээний талаарх (ямар эрхтэй, ямар үйлчилгээ авах боломжтой гэх мэт) мэдээллийг Банкны www.tdbm.mn цахим хуудсын бүтээгдэхүүний танилцуулга хэсэгт шинэчлэгдсэн байдлаар авна.
  - 3.3.12. Цахим гарын үсгээр баталгаажуулсан гэрээнд гарын үсэг зурж эх хувийг баталгаат шуудангаар банкинд ирүүлэх
  - 3.3.13. Банкны буруугаас алдаатай гүйлгээ хийгдсэн тохиолдолд тухайн алдаатай гүйлгээг Банк Харилцагчийн харилцах болон хугацаагүй хадгаламжийн данснаас үл маргах журмаар суутган авч, залруулахыг Харилцагч нь Банканд үүгээр зөвшөөрсөн. Ийнхүү Банк алдаатай гүйлгээг залруулсныг Харилцагчийн бичгээр өгсөн үүрэг буюу зөвшөөрлийн үндсэн дээр гүйцэтгэсэн гүйлгээ гэж үзнэ;
  - 3.3.14. Нэвтрэх эрхийг зөвшөөрөлгүйгээр ашиглан ТиДиБи Онлайн болон Мост Мони үйлчилгээнд хандалт хийснийг мэдсэн тохиолдолд Банканд нэн даруй хандах.
  - 3.3.15. Гэрээгээр хүлээсэн үүрэг бүрэн биелүүлэх.
- 3.4. Харилцагч дараах эрх эдлэнэ. Үнд:**
- 3.4.1. Банкны үйлчилгээний хүү шимтгэлийн сөрөнхий нөхцөл болон БҮЕН, орсон нэмэлт, өөрчлөлтүүдийг хүлээн зөвшөөрөхгүй бол нийтэд мэдээлсэн өдрөөс ажлын 30 хоногийн дотор Банканд хандан санал, хүсэлт гаргах;
  - 3.4.2. Данс, карт болон банкны бусад бүтээгдэхүүн, үйлчилгээг банкны цахим сувгуудыг ашиглан захиран зарцуулах, тохиргоо, мэдээллийг бичгээр гаргасан хүсэлтийн дагуу эсхүл цахим сувгуудаар дамжуулан өөрчлөх, шинээр авах, эрхээ сэргээлгэх болон хаалгах;
  - 3.4.3. Банканд бичгээр хүсэлт гарган, нотариатаар баталгаажуулсан гэрээсэлд, өвлөх эрхийн гэрчилгээ болон итгэмжлэлээр өөрийн өв залгамжлагч болон данс ашиглах эрх бүхий этгээдийг тодорхойлох;
  - 3.4.4. Хүсэлт гарган Банкны бүтээгдэхүүн, үйлчилгээг шинээр авах, эрхээ сэргээлгэх болон хаалгах;
  - 3.4.5. Гэрээгээр хүлээсэн үүрэг биелүүлэхийг Банкаас шаардах;
  - 3.4.6. Банктай байгуулсан гэрээг хугацаанаас өмнө цуцлах, эсхүл сонгосон үйлчилгээнээс татгалзах;
  - 3.4.7. Банкны буруутай үйл ажиллагааны улмаас учирсан зардал, хохирлыг банкаар төлүүлэх;
  - 3.4.8. Хуульд заасан бусад эрх эдлэх.

**ДӨРӨВ. МАРГААН ШИЙДВЭРЛЭХ**

- 4.1. Төлбөр, тооцооны үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой Банк, Харилцагч болон Банкны гэрээт үйлчилгээ үзүүлэгч байгууллага эсхүл хүлээн авагчийн хооронд үүссэн маргаантай асуудлыг харилцах, үйлчилгээний байгууллага эсхүл хүлээн авагчийн аль нэг талын хүсэлтээр 3 талын оролцоотойгоор хамтран зөвшилцөх журмаар шийдвэрлэнэ.
- 4.2. Банк, Монгол Улсын бусад банк болон гадаадын банкны сүлдэнд гарсан картын төлбөр тооцоо, МостМони, ТиДиБи Онлайнээр хийгдсэн төлбөр тооцоотой холбоотой маргааныг энэхүү гэрээ, Виза Интернэшнл, Мастеркарт Ворлдвайд болон ЮнионПэй Интернэшнл байгууллагуудын маргаантай гүйлгээ шалгаж шийдвэрлэх журам, Монголбанкны болон ХХБ-ны маргаан шийдвэрлэх заавар, журам, “ХХБ болон Гэрээт банктай байгуулсан хамтран ажиллах гэрээ” болон бусад хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ. Гомдлыг шийдвэрлэх Ерөнхий хугацаа 180 хоног байх бөгөөд тухайн маргааны төрлөөс шалтгаалан холбогдох журамд заасны дагуу тодорхойлогдоно.
- 4.3. Хэрэв Гэрээний 4.1-4.2-д заасан журмаар маргааныг шийдвэрлэх чадахгүй бол Монгол Улсын хуулийн дагуу, Монгол Улсын Шүүхээр эцэслэн шийдвэрлүүлнэ.

**ТАВ. ГЭРЭЭ ЦУЦЛАХ, ДУУСГАВАР БОЛОХ, ДАНС ХААХ**

- 5.1. Дараах тохиолдолд энэхүү гэрээг цуцалж, дуусгавар болгоно. Үүнд:
  - 5.1.1. Харилцагчийн хүсэлтийг үндэслэж гэрээг цуцалж, дуусгавар болгоно. Гэрээг цуцалсанаар харилцагчийн бүтээгдэхүүн, үйлчилгээг эзэмших эрхийг цуцалж, данс болон бусад бүтээгдэхүүн, үйлчилгээний эрхийг хаана.
  - 5.1.2. Хэрэв харилцагч нь данс болон бүтээгдэхүүн үйлчилгээтэй холбогдох аливаа өр төлбөрийг бүрэн барагдуулаагүй бол тухайн төлбөрийг барагдуулж дуустал дансанд битүүмж тавьж, барагдуулж дууссан өдрөөс гэрээг цуцалж, гэрээний хугацааг дуусгавар болсонд тооцож, харилцагчийн дансыг хаана.
  - 5.1.3. Харилцагч нь Гэрээгээр хүлээсэн үүргээ ноцтой зөрчсөн тохиолдолд Банк гэрээг нэг талын санаачилгаар цуцалж, бүтээгдэхүүн, үйлчилгээг хэрэглэх эрхийг дуусгавар болгоно.
  - 5.1.4. Харилцагч өөрийн дансыг төлбөр тооцооны бус зориулалтаар удаа дараа (2 болон түүнээс дээш) ашигласан (бусдын нэр дээр банкны баталгаа, тодорхойлолт гаргах үйлчилгээ эрхлэх, дансыг ашиглан бусад хохирол учруулж болзошгүй буюу залилан луйврын шинжтэй үйлдэл гарах нөхцөл бүрдүүлэх үйл ажиллагаа) болон Банканд, гуравдагч этгээдэд хохирол учруулах үйлдлийг удаа дараа гаргасан тохиолдолд Банк гэрээг дангаар цуцалж, данс болон бүтээгдэхүүн, үйлчилгээний эрхийг хаах эрхтэй.
  - 5.1.5. Хуульд заасан бусад үндэслэлээр.

- 6.1. Харилцагч төлбөр тооцооны баримтыг хуурамчаар үйлдэх, залилан мэхлэх болон гэрээгээр хүлээсэн бусад үүргийг зөрчих замаар Банканд хохирол учруулсан бол хохирлыг дансан дахь мөнгөн хөрөнгөөс үл маргах журмаар төлнө.
- 6.2. Харилцагчийн дансны үлдэгдэл хүрэлцээгүй, төлбөр тооцооны баримтын бүрдүүлбэр дутуу, буруу болон хүлээн авагч банкны үйлчилгээний доголдол зэрэг шалтгааны улмаас харилцагчийн төлбөр саатсан бол үүсэх үр дагаврыг банк хүлээхгүй.
- 6.3. Талуудын аль нэг нь гэрээг зөрчсөнөөс нөгөө талдаа учирсан бодит хохирол, зардлыг гэрээг зөрчсөн тал бүрэн хариуцна.
- 6.4. Энэхүү гэрээ цуцлагдсан, дуусгавар болсон тохиолдолд энэ гэрээг хүчин төгөлдөр байх үед үүссэн төлбөр тооцооны эрх, үүрэг нь бүрэн биелэгдэж дуусах хүртэл хугацаанд энэ гэрээний зохицуулалт нь талуудын хувьд хүчин төгөлдөр мөрдөгдөнө.
- 6.5. Харилцагч нь өөрийн дансны дугаар, карт болон картын дугаар, хүчинтэй хугацаа, CVV код, пин код, интернэт пин код болон соронзон туузны нууцлалын мэдээлэл, бусад бүтээгдэхүүн, үйлчилгээнд ашиглах харилцагчийн нэвтрэх нэр, нууц үг, гүйлгээний нууц үг, нэг удаагийн нууц дугаар, ТАН код болон бусад нууцлалын мэдээллийг гуравдагч этгээдэд аливаа хэлбэрээр дамжуулахгүй, алдахгүй байх, хэрэв дамжуулсан болон алдсаны улмаас хохирол учирвал түүнийг бүрэн хариуцна.
- 6.6. Бүтээгдэхүүн, үйлчилгээг ашиглах явцад харилцагч нь энэхүү гэрээнд заасан үүргийг биелүүлээгүйгээс Банканд болон гуравдагч этгээдэд санаатай болоод санамсаргүйгээр үүсгэсэн /үүсэх аливаа хохирол, зардал, асуудлыг харилцагч бүрэн хариуцна.
- 6.7. Харилцагч Америкийн Нэгдсэн Улсын харьяат иргэн бол W-9 маягтад заасан өөрийн болон дансны мэдээлэл, TIN эсхүл SSN эсхүл EIN дугаарыг АНУ-ын Internal Revenue Service (IRS)-д мэдээлэх зорилгоор Банканд мэдэгдэх, мэдэгдэгүйн улмаас үүсэх хариуцлагыг харилцагч хариуцна.

**ДОЛОО. БУСАД ЗҮЙЛ**

- 7.1. Энэхүү гэрээг бичгээр байгуулах тохиолдолд хоёр хувь үйлдэж, Талууд тус бүр нэг хувийг хадгална. Харин энэ гэрээг цахим хэлбэрээр (Ти Ди Би Онлайн) байгуулах тохиолдолд Банканд Харилцагчийн зөвшөөрсөн үйлдэл (гэрээг зөвшөөрсөн тухай мэдээлэл) хадгалагдана. Дээрх хоёр тохиолдол хууль зүйн хувьд адил хүчинтэй.
- 7.2. Харилцагч Гэрээний 2.2-д заасан бүтээгдэхүүн, үйлчилгээг авахдаа Банкаас үзүүлж буй цахим сувгийг ашигласан нь Харилцагч Банканд өөрийн биеэр ирж, төлбөр тооцооны баримтаар гүйлгээ хийлгэж, үйлчлүүлсэнтэй адил тооцогдож, хүчин төгөлдөр байна.
- 7.3. Харилцагч төлбөр тооцоог гадаад валютаар гүйцэтгэхэд тухайн цаг хугацаанд Банкаас зарласан арилжааны ханш, олон улсын сүлжээг ашиглах бол тухайн банкны хүү, шимтгэл, ханшийг хүлээн зөвшөөрч, гүйлгээ хийхийг Талууд үүгээр харилцан тохиролцов.
- 7.4. Гэрээний дагуу эзэмшиж байгаа данс, данс дахь дундын өмчийн хөрөнгийг харилцагч болон хамтран эзэмшигч хэн нэгнээсээ тухай бүрт зөвшөөрөл авахгүйгээр захиран зарцуулахыг үүгээр зөвшөөрч байна. Цаашид данснаас гүйлгээ хийх бүрд данс дахь мөнгөн хөрөнгийг захиран зарцуулах зөвшөөрөл бие биедээ олгохгүй бөгөөд Иргэний хуулийн 108 дугаар зүйлийн 108.4 дэх хэсэгт заасан зөвшөөрөл олгогдсоноор тооцохоор талууд харилцан тохиролцов. (Энэхүү нөхцөл нь дансыг хамтран эзэмших тохиолдолд хамаарна, мөн харилцагч дансанд хамтран эзэмшигч бүртгүүлэхдээ данснаас хөрөнгө захиран зарцуулах хэмжээг зааж хязгаарласан тохиолдолд хамаарахгүй болно)
- 7.5. Харилцагч энэхүү гэрээний 2.2-д заасан банкны бүтээгдэхүүн, үйлчилгээнээс хэсэгчлэн болон дахин авсан тохиолдолд тухайн авч буй бүтээгдэхүүн, үйлчилгээнд энэхүү гэрээний нөхцөл мөрдөгдөхөөр харилцан тохиролцов.

**ГАРЫН ҮСГИЙН БАТАЛГАА\***

| Харилцагчийн эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр | Регистрийн дугаар | Баталгаат гарын үсгийн маяг |
|---|-------------------|-----------------------------|
| .....                                     | .....             | .....                       |

\*Харилцагч төлбөр тооцооны баримтад гарын үсэг зурахдаа энэхүү маягтад батлуулсны дагуу зурна.

**Гэрээний нөхцөлийг бүрэн уншиж танилцсан бөгөөд гэрээний нөхцөл болон БҮЕН, ХШЕН-ийг хүлээн зөвшөөрч баталгаат гарын үсгээ зурав:<sup>1</sup>**

Банкийг төлөөлж: \_\_\_\_\_ Харилцагч: \_\_\_\_\_

.....

БМА-ны нэр: \_\_\_\_\_ Нэр: \_\_\_\_\_

Ахлах ажилтан: \_\_\_\_\_ И-мэйл хаяг: \_\_\_\_\_

Утас: \_\_\_\_\_

<sup>1</sup> Харилцагч нь 18 нас хүрээгүй иргэн бол түүний эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч хүлээн зөвшөөрч баталгаат гарын үсгээ зурав.